



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/596

Арвайхээр

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл
олгох тухай

Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын 2019 оны 254, 255 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийн дагуу Арвайхээр сумын математик, гадаад хэлний гүнзгийрүүлсэн, урлагийн төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын “Тэмүүлэл-Эрдэм” сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, Арвайхээр сумын Цэцэрлэг бага сургуулийн бүтэц, хэв шинж өөрчлөгдсөнтэй холбогдуулан Арвайхээр сумын 13 дугаар цэцэрлэгийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 2019 оны 08 дугаар сарын 19-ний өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдөр хүртэл, Арвайхээр сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 2019 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр хүртэл тус бүр 5 жилийн хугацаатай олгосугай.

2. Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон дээрх байгууллагуудын сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101095